“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЖУРАМ

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЖУРАМ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ....2
ХОЁР. ДАХИН АРИЛЖААЛАХ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН....2
ГУРАВ. ХУДАЛДАХ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ....3
ХУДАЛДАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ....3
ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ....4
ТАВ.АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ....5
ЗУРГАА.ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН....5
ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО....6
НАЙМ. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ....7
ЕС.АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ....7
АРАВ.АРИЛЖААТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН....8
АРВАН НЭГ.БУСАД....8
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын....9
Хавсралт 1....9
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын....11
Хавсралт 2....11
“Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам”-ын....12
Хавсралт 3....12

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЖУРАМ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмаар "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх)-иар арилжигдсан нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах захиалгыг хүлээн авах, арилжааг зохион байгуулах, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, захиргааны хэм хэмжээний акт, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх) болон Биржээс баталсан бусад журам, зааврааар зохицуулна.

1.3. Энэхүү журмыг Бирж, Биржийн арилжаанд оролцогчид, Биржийн зах зээлийн бусад оролцогчид дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1. "форвард гэрээг дахин арилжаалах" гэж нүүрсний форвард гэрээний анхны худалдан авагч нь тухайн гэрээний дагуу худалдагчаас шаардах эрхээ Бирж дээр арилжаалах замаар эрх, үүрэг шилжүүлэх үйл ажиллагааг;

1.4.2. "нийлүүлэгч" гэж Биржээр нүүрс арилжаалсан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компанийг;

1.4.3. "худалдагч" гэж форвард гэрээний шаардах эрхээ арилжаалах захиалга ирүүлсэн худалдан авагч хуулийн этгээдийг;

1.4.4. "худалдан авагч" гэж Биржид худалдан авагчаар бүртгүүлж, гэрээ байгуулсан энэ журмын 1.4.1-д заасан арилжаанд худалдан авагчаар оролцох хуулийн этгээдийг;

1.4.5. "хүндэтгэн үзэх шалтгаан" гэж гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, төрийн эрх бүхий байгууллагын хориг, хязгаарлалтыг ойлгох ба энэ нь тухайн улсын эрх бүхий байгууллагын гэрчилгээ, дүгнэлт, тодорхойлолтоор тогтоогдсоныг.

ХОЁР. ДАХИН АРИЛЖААЛАХ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН

2.1. Дахин арилжаалах нүүрсний форвард гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. гэрээний нийт төлбөр нь бүрэн төлөгдсөн байх (дэнчин хассан дүнгээр);

2.1.2. гэрээний хугацаа дуусгавар болоогүй байх.

2.2. Биржээр дахин арилжаалах нүүрсний хэмжээг тонноор илэрхийлсэн байна.

2.3. Биржээр дахин арилжаалах нүүрсний форвард гэрээ нь биржээр арилжигдсан анхны арилжааны зард тусгасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлттэй ижил байна.

2.4. Биржээр арилжаалагдсан нүүрсний чанарын шаардлагыг нийлүүлэгч тал хариуцах бөгөөд нүүрсний чанарыг бууруулахгүй байхад шаардагдах арга хэмжээг авч ажиллана.

2.5. Форвард гэрээг дахин арилжаалсан тохиолдолд анх байгуулсан форвард гэрээг худалдан авагч тал үргэлжлүүлэн форвард гэрээний дагуу худалдан авагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

2.6. Форвард гэрээг дахин арилжаалах захиалга ирүүлсэн хэдий ч арилжаа амжилтгүй болсон форвард гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

ГУРАВ. ХУДАЛДАХ ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

ХУДАЛДАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ

3.1. Худалдагч нь худалдах захиалгыг Биржийн арилжааны системд цахимаар оруулах бөгөөд захиалгын үнэн зөвийг Худалдагч өөрөө хариуцна.

3.2. Худалдагч нь Биржээр арилжаалах нүүрсний захиалгыг дараах баримт бичгийн хамт арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Биржийн арилжааны системд оруулна. Үүнд:

3.2.1. энэхүү журмын Хавсралт 1-т заасан “Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах захиалга”;

3.2.2. хүчин төгөлдөр форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;

3.2.3. Биржээр арилжигдсан форвард гэрээний төлбөр төлсөн баримт;

3.2.4. нийлүүлсэн нүүрсний тоо хэмжээг баталгаажуулсан тооцоо нийлсэн акт;

3.2.5. эрх шилжүүлэх гэрээ; (худалдагч тал гарын үсэг зурж, тамга дарж урьдчилан баталгаажуулсан байх)

3.2.6. бүртгэх үйлчилгээний хөлс төлсөн баримт;

3.3. Бирж нь захиалгатай холбоотой шаардлагатай нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичгийг худалдагчаас гаргуулан авч болно.

3.4. Энэхүү журмын 3.2.4-т заасан тооцоо нийлсэн актад дахин арилжаалах боломжтой нүүрсний хэмжээ, нийлүүлэгч нь дахин арилжаалах нүүрсийг гэрээний хугацаанд нийлүүлж дуусах хуваарь, форвард гэрээний хугацааг түдгэлзүүлсэн огноо, форвард гэрээний худалдан авагчийн эрх, үүргийг шилжүүлэхийг зөвшөөрсөн нийлүүлэгч талын мэдэгдэл болон форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл зэрэг шаардлагатай мэдээллийг заавал тусгана.

3.5. Форвард гэрээний худалдан авагчийн эрхийг шилжүүлэн авсан этгээд нь анхны худалдан авагчийн форвард гэрээний үүргийн зөрчлөөс шалтгаалж алданги, хохирол төлөх үүргийг нийлүүлэгчийн өмнө хүлээхгүй.

3.6. Бирж нь худалдагчийн захиалгыг бүртгэсний дараа болон арилжаа зохион байгуулагдсаны дараа нийлүүлэгч талд захиалгад тусгасан тоо хэмжээний нийлүүлэлтийг түр зогсоох, үргэлжлүүлэх мэдэгдлийг тухай бүр хүргүүлнэ.

3.7. Худалдах захиалга нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар бүртгэж, арилжааны системд оруулах ба арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө энэ журмын 3.2-т заасан баримт бичгүүдийг бүрэн оруулсан тохиолдолд

арилжааны зарыг эрх шилжүүлэх гэрээний төсөл, форвард гэрээний хамт Биржийн цахим хуудсанд нийтэлнэ.

3.8. Дараах тохиолдолд Бирж худалдах захиалгыг бүртгэхээс татгалзана. Үүнд:
- 3.8.1. энэхүү журмын 2.2-т заасан шаардлага хангаагүй;
- 3.8.2. захиалгын мэдээлэл болон бүрдүүлбэр дутуу;
- 3.8.3. энэхүү журмын 3.11-т заасныг зөрчсөн;
- 3.8.4. Биржээс шаардсан захиалгатай холбоотой нэмэлт мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй.

3.9. Бирж нь энэхүү журмын 3.8-т заасан үндэслэлээр худалдах захиалгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай худалдагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.10. Форвард гэрээг дахин арилжаалахад худалдан авагч үнийн санал ирүүлээгүй болон бусад шалтгаанаар арилжаа амжилтгүй болсон бол худалдагч нь тус арилжааны захиалгыг ажлын 2 өдрийн дотор дахин нэг удаа биржид бүртгүүлж болно.

3.11. Энэхүү журмын 3.10-д заасан шалтгаанаар хоёрдох удаагаа арилжаа амжилтгүй болсон тохиолдолд тухайн гэрээг дахин арилжаалах захиалгыг Бирж бүртгэхгүй. Энэ тохиолдолд Форвард гэрээний анхны худалдан авагч болон нийлүүлэгчид тухайн форвард гэрээг нэн даруй үргэлжлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар Бирж мэдэгдэнэ.

3.12. Форвард гэрээний худалдан авагчийн эрхийг шилжүүлэн авсан этгээд нь тухайн гэрээг дахин Бирж дээр арилжаалахгүй.

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГА, ТҮҮНИЙГ ХҮЛЭЭН АВАХ

4.1. Биржид бүртгэлтэй худалдан авагч нь өөрөө эсхүл Биржийн гишүүн брокероор дамжуулан арилжаанд оролцож болно.

4.2. Худалдан авагч, брокер нь худалдан авах захиалга өгөх, арилжаанд оролцохдоо дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 4.2.1. Биржээс олгосон арилжааны системд хандах эрхээр нэвтэрч арилжаанд оролцох;
- 4.2.2. өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийн бэлэн байдлыг хангаж арилжаанд оролцох;
- 4.2.3. арилжааны системд нэвтрэх эрхийг бусдад дамжуулах, шилжүүлэх нууцлалыг алдагдуулахгүй байх, арилжааны системд нэвтрэх эрхгүй этгээд нэвтэрсэн, зохих зөвшөөрөлгүйгээр арилжааны системд үйлдэл хийснээс үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 4.2.4. арилжааны заавар, зөвлөмж, анхааруулга, албан ёсны зартай сайтар танилцсан байх;
- 4.2.5. арилжаатай холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Биржийн дүрэм, журамтай танилцсан байх;
- 4.2.6. арилжааны системтэй холбоотой ямар нэг доголдол илэрвэл Биржид яаралтай мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

4.3. Худалдан авагч, түүний брокер нь арилжааны системд оруулах захиалгын үнэн зөв, түүнээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.

4.4. Брокер нь өөрийн системийн доголдлоос үүссэн хохирлыг худалдан авагчийн өмнө үл маргах журмаар хариуцна.

ТАВ.АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5.1. Бирж арилжааг ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд зохион байгуулна.

5.2. Бирж нь захиалгыг худалдагчаас ирүүлсэн доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэйгээр арилжина.

5.3. Арилжааны дуудах доод үнийн хамгийн бага өөрчлөлтийн хэмжээ худалдагчийн ирүүлсэн захиалгад өөрөөр тогтоогоогүй тохиолдолд тонн тутамд 0.3 ам.доллар эсхүл 3 юаньтай дүйцэхүйц байна.

5.4. Бирж нь худалдахаар зарласан нэг захиалгыг нэг худалдан авагчид худалдана.

5.5. Арилжаа нь дараах 3 үе шаттайгаар явагдана:

5.5.1. захиалга бүртгэх үе;

5.5.2. дуудах үе;

5.5.3. хэлцэл хийгдэх үе.

5.6. Худалдан авах захиалга бүртгэх үе нь 60 минутын хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед худалдан авах захиалгыг өөрчлөх эсхүл цуцалж болно.

5.7. Захиалга бүртгэх болон дуудах үед Биржийн арилжааны систем худалдан авах захиалгыг үнээр эрэмбэлэх бөгөөд ижил үнэтэй захиалгуудын хувьд цаг хугацааны дараалаар эрэмбэлнэ.

5.8. Худалдан авагч нь захиалга бүртгэх үед захиалгаа цуцалсан болон оруулаагүй бол дуудах үед захиалга оруулах боломжгүй.

5.9. Худалдан авах захиалга бүртгэх үе дууссаны дараа дуудах үе нь 1 минут үргэлжлэх бөгөөд энэ үед үнийг бууруулах, захиалгыг цуцлах боломжгүй.

5.10. Дуудах үед хамгийн дээд үнэ шинэчлэгдэх тохиолдол бүрд дуудах үе дахин 1 минутын хугацаагаар сунгагдана.

5.11. Дуудах үеийн 1 минутын хугацаанд дээд үнэ шинэчлэгдээгүй тохиолдолд хамгийн дээд үнийн саналаар хэлцэл хийгдэнэ.

5.12. Энэхүү журмын 5.11-т заасны дагуу хэлцэл хийгдсэнээр тухайн арилжаа дуусгавар болно.

ЗУРГАА.ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

6.1. Бирж нь арилжаа зохион байгуулагдаж дууссанаас хойш тухай бүр арилжааны мэдээг өөрийн албан ёсны цахим хуудсаар мэдээлэх бөгөөд хэлцэл амжилттай хийгдсэн тохиолдолд баталгаажсан хэлцлийн тайланг худалдагч, худалдан авагч, нийлүүлэгчид тухай бүр цахимаар хүргүүлнэ.

6.2. Худалдагчид хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

6.2.1. Биржээр арилжигдсан форвард гэрээний дугаар;

6.2.2. хэлцэл хийгдсэн үнэ, хэлцлийн дугаар;

6.2.3. худалдан авагчаар шалгарсан хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг;

6.2.4. эрх шилжүүлэх гэрээг баталгаажуулах хугацаа.

6.3. Нийлүүлэгч талд хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

6.3.1. Биржээр арилжигдсан форвард арилжааны гэрээний дугаар;

6.3.2. хэлцлийн дугаар;

6.3.3. худалдан авагчаар шалгарсан хуулийн этгээдийн албан ёсны нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл хаяг.

6.4. Худалдан авагч эсхүл түүний брокерт хүргүүлэх баталгаажсан хэлцлийн тайланд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:
6.4.1. худалдагч болон нийлүүлэгч талын албан ёсны нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг;
6.4.2. хүчин төгөлдөр форвард гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;
6.4.3. эрх шилжүүлэх гэрээг баталгаажуулах хугацаа;
6.4.4. төлбөр тооцоо гүйцэтгэх хугацаа, нөхцөл;
6.4.5. арилжааны шимтгэл төлөх хугацаа зэрэг мэдээлэл.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1. Гэрээний үнэ, дэнчин, арилжааны шимтгэлийг анхдагч арилжааны валютаар тодорхойлно.

Дэнчин байршуулах

7.2. Худалдан авагч нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө арилжааны дэнчинг Биржийн тусгайлан нээсэн дансанд байршуулсан байна.
7.3. Худалдан авагч нь дэнчинг байршуулахдаа арилжааны банкин дахь өөрийн нэрийн данснаас шилжүүлэх бөгөөд гүйлгээний утга хэсэгт компанийн оноосон нэр, Биржийн арилжааны систем дэх компанийн бүртгэлийн дугаар болон "арилжааны дэнчин" гэх утгыг тусгана.
7.4. Худалдан авагчийн байршуулах биржийн дэнчингийн хэмжээ нь нүүрсний доод үнээр илэрхийлсэн худалдах захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү байна.

Арилжааны шимтгэл, үйлчилгээний хөлс

7.5. Арилжаанд шалгарсан худалдан авагч нь арилжааны шимтгэл төлөх бөгөөд уг шимтгэл нь хэлцлийн нийт үнийн дүнгийн 0.05 хувьтай тэнцүү байна.
7.6. Брокероор дамжуулан арилжаанд оролцсон тохиолдолд энэхүү журмын 7.5-т заасан шимтгэл 0.04 хувьтай тэнцүү байна.
7.7. Худалдагч нь ирүүлсэн захиалгын 1 тонн тутамд 15 төгрөг түүнтэй тэнцэх гадаад валют (ам.доллар, юань)-аар бүртгэх үйлчилгээний хөлс төлнө.
7.8. Энэхүү журмын 7.7-т заасан хөлсийг гадаад валютаар төлсөн тохиолдолд тухайн өдрийн Монголбанкны ханшаар тооцон шилжүүлнэ.
7.9. Худалдан авагч нь арилжааны шимтгэлийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор төлнө.
7.10. Бирж нь бүртгэх үйлчилгээний хөлс, арилжааны шимтгэлийг буцаан олгохгүй.

Гэрээний төлбөр

7.11. Худалдан авагч нь гэрээний төлбөрийг арилжаа зохион байгуулагдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Биржийн дансанд нэхэмжлэхийн дагуу 100% шилжүүлнэ.
7.12. Журмын 7.11-т заасан гэрээний төлбөрийг Бирж нь баталгаажсан эрх шилжүүлэх гэрээг үндэслэн худалдагчийн дансанд шилжүүлнэ.

Дэнчинг буцаан шилжүүлэх

7.13. Арилжаа явагдаагүй, худалдан авах санал гаргагч тухайн арилжаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа зохион байгуулагдсан өдрөөс хойш Бирж нь худалдан авах санал гаргагчийн албан ёсны (тухайн хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг болон тамга тэмдэг дарсан албан тоот) хүсэлтийн дагуу ажлын 5 өдрийн дотор банкны гүйлгээний шимтгэлийг хассан дүнгээр дэнчинг буцаан олгоно.
7.14. Бирж нь худалдан авагчаар шалгарсан этгээдийн дэнчинг Журмын 7.11-т

заасны дагуу гэрээний төлбөр Биржийн дансанд байршсаны дараа худалдан авагчийн ирүүлсэн нэхэмжлэх, төлбөр төлсөн баримтыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор буцаан олгоно.

7.15. Энэ журмын 7.13, 7.14-т заасны дагуу дэнчинг буцаахдаа анх шилжүүлсэн дансанд, анх орж ирсэн валютаар шилжүүлнэ.

7.16. Энэ журмын 7.13-т заасан хүсэлт, 7.14-т заасан баримтыг ирүүлээгүй тохиолдолд дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээсэнд тооцно.

7.17. Хэлцэл амжилттай хийгдсэн боловч худалдан авагчаар шалгарсан этгээд нь гэрээний төлбөрийг хугацаандаа эсхүл бүрэн шилжүүлээгүй, эрх шилжүүлэх гэрээг ажлын 3 өдөрт багтаан баталгаажуулж, цахимаар ирүүлээгүй тохиолдолд Бирж нь дэнчинг арилжааны шимтгэл хассан дүнгээр худалдагчид шилжүүлнэ.

7.18. Журмын 7.17 дахь хэсэгт заасан үүргээ Худалдан авагч нь хүндэтгэн үзэх шалтгаантайгаар биелүүлээгүй тохиолдолд дээрх зохицуулалт хамаарахгүй.

НАЙМ. ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

8.1. Эрх шилжүүлэх гэрээг худалдагч худалдан авагч нь энэхүү журмын Хавсралт 3-т заасан загвараар бичгээр байгуулна.

8.2. Эрх шилжүүлэх гэрээ нь тухайн форвард гэрээний салшгүй хэсэг байна.

8.3. Арилжаанд шалгарсан худалдан авагч нь энэхүү журмын 8.1-т заасан Эрх шилжүүлэх гэрээг хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 3 өдрийн дотор баталгаажуулж, Биржийн арилжааны системээр ирүүлнэ.

8.4. Журмын 8.1-т заасан гэрээний хугацаа форвард гэрээний хугацаанаас хэтрэхгүй байх ба зөвхөн эрх шилжүүлэх гэрээгээр нэг удаа сунгалт хийх боломжтой байна.

8.5. Бирж нь баталгаажсан Эрх шилжүүлэх гэрээ, төлбөр төлсөн баримтыг хүлээн авснаас хойш ажлын 1 өдрийн дотор нийлүүлэгч талд хүргүүлж, тухайн форвард гэрээний нийлүүлэлтийг үргэлжлүүлэх талаар цахимаар мэдээлнэ.

ЕС.АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

9.1. Бирж нь арилжааны болон ханшийн мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд арилжааны систем болон цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлнэ.

9.2. Арилжааны мэдээнд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд:

9.2.1. арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр;

9.2.2. арилжаанд оролцсон нийт худалдан авах санал гаргагчдын тоо;

9.2.3. нийлүүлэгчийн нэр, албан ёсны хаяг;

9.2.4. захиалгын бүртгэлийн дугаар;

9.2.5. доод үнэ;

9.2.6. хэлцэл хийгдсэн үнэ;

9.2.7. гэрээний нийт үнийн дүн;

9.2.8. үнийн өсөлтийн хувь;

9.2.9. арилжсан нүүрсний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт;

9.3. Бирж нь арилжааны үнэ, хэмжээ, нүүрсний төрөл, ангилал, худалдан авагчийн оршин байгаа улс, арилжаа зохион байгуулагдсан он, сар, өдөр зэрэг үзүүлэлтээр өдөр, долоо хоног, сар, жилээр тогтмол мэдээлнэ.

9.4. Биржийн зах зээлийн оролцогчид нь Биржийн нийтэд зарласнаас бусад мэдээллийг задруулахыг хориглох бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу

худалдагч, худалдан авагчийн арилжааны мэдээллийн нууцыг чандлан хадгална.

АРАВ.АРИЛЖААТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН

10.1. Биржийн арилжаанд оролцогч нь Биржийн арилжаатай холбоотой гомдлоо арилжаа хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлд гаргаж болно.

10.2. Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлөөр маргаан шийдвэрлүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчилсан журмаар зохицуулна.

10.3. Энэ журмын 10.1-т заасан хугацаа өнгөрсөн эсхүл Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Монголын улсын шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

10.4. Хэрэв талууд Арбитрын хэлэлцээртэй бол биржийн арилжаанд оролцогчийн хооронд гарсан маргааныг Монгол Улсын Олон Улсын Арбитраар шийдвэрлүүлж болно.

АРВАН НЭГ.БУСАД

10.5. Энэхүү журмыг зөрчсөн арилжаанд оролцогчийн үйлдэл нь гэмт хэрэг эсхүл зөрчлийн шинжтэй бол эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

10.6. Энэхүү журмыг зөрчсөн арилжаанд оролцогчид Биржийн Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны хяналт шалгалтын журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.7. Арилжаанд оролцогчид нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамтай танилцаагүй нь журам болон гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

10.8. Энэхүү журмын хэрэгжилтэд Бирж хяналт тавина.

---o0o---

"Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-ын
Хавсралт 1.

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЗАХИАЛГА

Огноо:.....	Дугаар:.....	Улаанбаатар хот

Бид ..... [уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч аж ахуйн нэгж, түүнийг төлөөлж] энэхүү маягт, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд худалдан авагчид хүргэвэл зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Д/д	**Форвард гэрээ худалдагчийн мэдээлэл**	
1.1	Оноосон нэр:	
1.2	Бүртгэлтэй улс, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар:	
1.3	Хуулийн этгээдийн регистрийн дугаар:	
1.4	Үйл ажиллагааны чиглэл:	
1.5	Оршин байх албан ёсны хаяг: */Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/*	
1.6	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
1.7	Энэхүү маягттай холбоотой худалдагч талыг төлөөлөх этгээдийн нэр, албан тушаал, хаяг, холбоо барих утас:	
1.8	Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага эсхүл удирдлагын баг /байхгүй бол эрх бүхий албан тушаалтан/-ийн гишүүдийн товч мэдээлэл:	
1.9	Төлбөр, тооцоог гүйцэтгэх банк, дансны мэдээлэл:	
1.10	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл:	

2.	**Арилжаалах нүүрсний мэдээлэл**	
2.1	Арилжаалах нүүрсний тоо хэмжээ (тонн):	нийт ..... тонн
2.2	Нүүрсний төрөл ангилал:	
2.3	Нүүрсний чанарын үзүүлэлт: */Стандарт чанарын үзүүлэлтүүд/*	
2.4	Арилжаа зохион байгуулагдах огноо:	

<table>
<tr><td>2.5</td><td>Дуудах доод үнэ, валютын төрөл:</td><td></td></tr>
<tr><td>2.6</td><td>Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн, нэгж (tick size):</td><td></td></tr>
<tr><td>2.7</td><td>Дэнчингийн хэмжээ:</td><td></td></tr>
<tr><td>2.8</td><td>Дэнчин байршуулах дансны дугаар:</td><td></td></tr>
<tr><td>2.9</td><td>Чанарын шинжилгээ хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн мэдээлэл:
/нэр, хаяг, холбоо барих утас/</td><td></td></tr>
<tr><td>2.10</td><td>Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний товч дүгнэлт, чанарын үзүүлэлт:</td><td>Жишиг үзүүлэлт:
Хэмжигдэхүүн | Чанарын үзүүлэлт /Өөрчлөлтийн хувь*/
Үзүүлэлт 1
Үзүүлэлт 2
Үзүүлэлт 3
Үзүүлэлт 4</td></tr>
<tr><td>2.11</td><td>Нүүрс нийлүүлэх цэг</td><td></td></tr>
<tr><td>2.12</td><td>Нүүрс хүргэж өгөх сүүлийн хугацаа /огноо/:</td><td></td></tr>
<tr><td>2.13</td><td>Нүүрс нийлүүлэх хугацаа</td><td></td></tr>
<tr><td>2.14</td><td colspan="2">Нүүрс нийлүүлэх хуваарь
Нийлүүлэх хуваарьт өдөр | | |
Нийлүүлэх Хэмжээ /тонн/ | | | </td></tr>
</table>

/Бид энэхүү маягт болон түүнд хавсаргасан баримт, бичгийг төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэхийг зөвшөөрч байна/

Нүүрс арилжаалах захиалга баталгаажуулсан:

"....." ХХК/ХК-ийн Гүйцэтгэх захирал:

.....

Гарын үсэг (Тамга, тэмдэг) :

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Биржийн албан хэрэгцээнд/

.Захиалга хүлээн авсан ажилтны овог, нэр:	Захиалга хүлээн авсан огноо, цаг, минут:	Захиалга, түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

---o0o---

"Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-ын
Хавсралт 2.

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭГ ДАХИН АРИЛЖААЛАХ ЗАР

1	Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг	
2	Нүүрсний төрөл, ангилал	
3	Чанарын үзүүлэлт	*Хэмжигдэхүүн* / *Чанарын үзүүлэлт*
4	Нийт тоо хэмжээ	
5	Дуудах доод үнэ, валютын төрөл	
6	Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн	
7	Гэрээ дуусгавар болох хугацаа	
8	Хүргэлт хийх хугацаа, нөхцөл /хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд нийлүүлэлтийн хуваарь/	
9	Нүүрс нийлүүлэх цэг	
10	Тээвэрлэлтийн төрөл	
11	Дэнчингийн хэмжээ	
12	Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл	
13	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл	
14	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар	

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа				
Төлбөр төлөх хугацаа	Хэлцэл биелснээс хойш ажлын 3 өдрийн дотор			
Нийлүүлэх хэмжээ /тонн/				

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад зар дахь мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

---o0o---

"Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-ын
Хавсралт 3.

НҮҮРСНИЙ ФОРВАРД ГЭРЭЭНИЙ ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны .... дугаар сарын ... -ний өдөр | Дугаар: ..... | Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү "Форвард гэрээний худалдан авагчийн эрх, үүргийг шилжүүлэх гэрээ" (цаашид "**Гэрээ**" гэх)-г нэг талаас "....." (цаашид "**Эрх шилжүүлэгч**" гэх), нөгөө талаас "....." (цаашид "**Эрх хүлээн авагч**" гэх), нар (хамтад нь "**Талууд**", дангаар нь "**Тал**" гэх) нь "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "**Бирж**" гэх)-ийн ..... оны .... сарын ....-ны өдрийн ..... дугаартай арилжааны үр дүнд үндэслэн ... дугаар "....." гэрээний Худалдан авагчийн эрх, үүргийг шилжүүлэхээр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний мэдээлэл, эрх, үүрэг шилжүүлэх нөхцөл

2.1. Эрх хүлээн авагчийн эрх, үүргийг нь шилжүүлэн авах Форвард гэрээ (цаашид "Форвард гэрээ" гэх)-ний мэдээлэл:

1.1.	Гэрээний талууд	Худалдагч	
1.2.		Худалдан авагч	
1.3.	Форвард гэрээний огноо, дугаар		
1.4.	Нүүрсний төрөл, ангилал		
1.5.	Чанарын үзүүлэлт		
1.6.	Форвард гэрээний дагуу худалдсан нүүрсний тоо, хэмжээ	Нийт нүүрсний хэмжээ	
1.7.		Нийлүүлэлт хийгдсэн нүүрсний хэмжээ	
1.8.		Үлдэгдэл (Энэ гэрээний дагуу шилжүүлэх) нүүрсний тоо хэмжээ	
1.9.	Гэрээ дуусгавар болох хугацаа		
1.10.	Үлдэгдэл нүүрсийг нийлүүлэх нийлүүлэлтийн хуваарь		
1.11.	Тээвэрлэлтийн төрөл		
1.12.	Хүргэлт хийх нөхцөл		
1.13.	Нүүрс нийлүүлэх цэг		
1.14.	Нэмэлт мэдээлэл		

2.2. Эрх шилжүүлэх нөхцөл:

2.1	Нүүрсний тоо хэмжээ	
2.2	Үнэ (тонн тутамд)	

2.3	Нийт төлбөр	
2.4	Төлбөр төлөх хугацаа	

2.3. Энэ гэрээ нь форвард гэрээний салшгүй нэгэн хэсэг байна.
2.4. Эрх хүлээн авагч нь форвард гэрээний зүйл, заалттай нэг бүрчлэн танилцаж, гэрээнд заасан нөхцөл, эрх, үүргийг бүрэн биелүүлэхээ хүлээн зөвшөөрсний үндсэн дээр арилжаанд оролцсон болно.
2.5. Эрх хүлээн авагч нь арилжааны худалдан авагчаар шалгарч, хэлцэл биелснээр форвард гэрээний Худалдан авагчийн бүх эрх, үүрэг, хариуцлага Эрх хүлээн авагчид шилжсэнд тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

4.1. Эрх шилжүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
4.1.1. Гэрээний 2.2.3-д заасан төлбөрийг Биржийн "Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-д заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй.
4.1.2. Эрх шилжүүлэхээс өмнөх форвард гэрээний Худалдан авагчийн үүрэг, хариуцлага, түүнийг биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг хүлээх үүрэгтэй.
4.1.3. Эрх шилжүүлэгч нь дараах баталгааг гаргаж байгаа ба баталгааг зөрчсөнөөс Эрх хүлээн авагч талд учирсан хохирлыг хариуцан төлөх үүрэгтэй.
4.1.3.1. форвард гэрээг аль нэг талаас цуцлах эсхүл талууд харилцан тохиролцож дуусгавар болгоогүй, гэрээ хүчинтэй болно.
4.1.3.2. форвард гэрээнд гэрээний эрх, үүргийг шилжүүлэхийг хориглосон заалт байхгүй болно.
4.1.3.3. форвард гэрээний эрх, үүргийг шилжүүлэх талаар Худалдагчид урьдчилан мэдэгдэж, тооцоо нийлсэн, гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний нийлүүлэлтийг зогсоох арга хэмжээ авсан болно.
4.1.3.4. форвард гэрээний мэдээллийг худалдах захиалгад үнэн зөв оруулсан болно.
4.1.3.5. Эрх хүлээн авагч нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
4.1.4. Энэхүү гэрээний 2.1-т заасан форвард гэрээний дагуу Худалдан авагчийн эдлэх эрхийг эдлэх эрхтэй;
4.1.5. Энэхүү гэрээний дагуу шилжүүлэн авсан форвард гэрээний эрх, үүргийг Биржийн арилжаагаар дахин худалдах эрхгүй;
4.1.6. Энэхүү гэрээний дагуу шилжүүлэн авсан форвард гэрээний дагуу Худалдан авагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээх үүрэгтэй
4.1.7. Хэлцэл биелсний дараа Биржийн "Нүүрсний форвард гэрээг дахин арилжаалах журам"-д заасан хугацаанд гэрээний төлбөрийг Эрх шилжүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй.

Тав. Гэрээг дуусгавар болгох

5.1. Энэхүү гэрээ нь форвард гэрээ дуусгавар болох хүртэл хугацаанд үргэлжилнэ.
5.2. Эрх шилжүүлэгч нь худалдах захиалга, форвард гэрээний мэдээллийг буруу оруулснаас Эрх хүлээн авагч нь арилжаанд оролцож, шалгарсан бол Эрх хүлээн авагч нь энэхүү гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй байна.

Зургаа. Бусад

6.1 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй харилцааг Талууд нэмэлт гэрээ байгуулан

зохицуулж болно. Талууд нэмэлт гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож чадаагүй нь системд хийгдсэн хэлцлийг хүчингүй болгох, энэ гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2 Талууд энэ гэрээний 6.1-т заасны дагуу нэмэлт гэрээ байгуулсан тохиолдолд Биржид мэдэгдэн, бүртгүүлнэ.

6.3 Энэхүү гэрээтэй холбоотой Талуудын хооронд үүссэн маргаан, үл ойлголцлыг зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх ба Талууд тохиролцоонд хүрээгүй бол маргааныг Монголын Олон Улсын арбитраар Монгол Улсын хуулийн дагуу тус арбитрын дүрмээр шийдвэрлүүлнэ.

6.4 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй, арилжаатай холбоотой бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам Арилжаа зохион байгуулагч болох "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн баталсан журам, зааврaар зохицуулна.

6.5 Энэхүү Гэрээг Монгол, Англи, Хятад хэл дээр үйлдсэн нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

6.6 Хэрэв Монгол, Англи, Хятад хэл дээрх гэрээний утга хоорондоо зөрвөл Монгол хэл дээрх гэрээний утгыг зөв гэж үзнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эрх шилжүүлэгч тал	Эрх хүлээн авагч тал
.....	.....
/...../	/...../
/Тамга/	/Тамга/
Хаяг:	Хаяг:
Утас:	Утас:

---o0o---